



Эрх чөлөө мандсан
Энхрийн Монгол орон минь
Дархан сайхан хилээ
Даалгаж биднээр мануулав.

Ай хо баатрууд минь
Халхралгүй зүтгэцгээ.

(Улсын баатар Н.Жамбаа гуайн
дуулах дуртай дууны үгээс)



ADMON
PRINTING, PUBLISHING & MORE



Халхын голын дайны панорам

ХАЙРТ ЭХ ОРНЫХОО ТӨЛӨӨ



УЛСЫН БААТАР НОРПИЛЫН ЖАМБАА

УЛААНБААТАР
2012 ОН

Монгол Улсын Хил судлалын төв

Хил хамгаалах байгууллагын 80 жилийн ойд



**Улсын баатар
Норпилын Жамбаа**

Хянан тохиолдуулсан. Э.Лувсанбалдан
(Түүхийн ухааны доктор, профессор)

Улаанбаатар
2012 он

DDC

920

Л-82

Эрт айлын хаяа дархан хилийн дээсэн дээр
Энх тайвны харуул дайчин эрсийн тангараг дээр
Эрдэнэ зуугийн хэрмийн зуун найман суврага дээр
Энэ зууны өргөөний зуун түмэн цонхон дээр
Тусгаар тогтнол чамайг тунхлан бичнэ би.

*Д.Пүрэвдорж. (Ардын уран зохиолч,
Төрийн шагналт яруу найрагч)*

Улсын баатар Норпилын Жамбаа

үсгийг хянасан: Н.Даваадорж

Д.Загдрагчаа

Цахим эхийг бэлтгэсэн: Б.Ганчимэг

*Энэхүү номыг Хил Хамгаалах Ерөнхий Газар,
“Н.Жамбаа” сан ивээн тэтгэв.*

Цаасны хэмжээ А5

Хэвлэсэн тоо 500

Хэвлэлийн хуудас 20

ADMON компанид эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN 987-99962-0-690-0

ӨМНӨТГӨЛ

Жамбаа гуай бол алдар хүндийн дээдийг эзэгнэсэн, бага балчираасаа хагацал өнчирлийн гасланг амсаж, эмэг эхийн гар дээр хүмүүжихдээ хал үзэж, хашир сууснаар өөрийгөө нээж, зориг хатуужлын дээдийг эзэмшиж нутаг усныхаа үе тэнгийнхний дундаас цойлж гарсан нэгэн. Түүний амьдралд тохиолдсон үйл явдлыг тодотгосон хамтран зүтгэгчдийн дурсамж, зохиолч, сэтгүүлчид туурвиж олны хүртээл болгосон ном, сонин, кино дэлгэцийн зохиол, хуурцагт хураасан ярилцлагыг эмхэтгэж, уншигч Таны мэлмийн дор өргөн барьж байна.

Энэхүү эмхэтгэл нь аавынхаа дурсгалыг мөнхжүүлэхийг дээдэлсэн Жамбаа баатрын үр хүүхдүүдийн цогц арга хэмжээний нэг юм. Жамбаа гуайн хүүхдүүд аавыгаа орчлон хорвоогоос халин одоход нүд дүүрэн нулимстай хоцорсны дараа амьдарч байсан орон байрыг нь гэр музей болгон зэвсэгт хүчнийхэнтэй хамтран ёслол төгөлдөр нээж, баримтат кино бүтээж, нэрэмжит сан буй болгоод, тэр сангаас эцгийнхээ гарамгай мэргэн буудагч байсныг санагалзан баатрын нэрэмжит алтан медаль, үнэмлэх, яам, албан газруудын хүндэт тэмдгээс нэг дахин өндөр мөнгөн урамшил бүхий шагнал буй болгож, түүгээрээ Жанжин штаб, Хилийн цэргийн штабтай хамтран жил бүр мэргэн буудагчийн тэмцээнд тэргүүлэгчдийг урамшуулан, өсөж төрсөн Баянхонгор аймгийн төвд сайн санаат хүмүүстэй санаа нэгдэн боржин чулуун хөшөө сүндэрлүүлэхэд хөрөнгө оруулж, Хилийн цэргийн Жамбаа баатрын нэрэмжит



заставт босгосон хөшөөний нээлтэд бололцооны хэрээр оролцож, уугуул нутаг Баянхонгор аймгийн Богд суманд бүтээх хөшөөнийх нь зураг төслийг бэлэн болгох зэрэг олон ажил амжуулжээ. Чингэхэд бурхан болсон баатруудын ар талынхны дотор Жамбаа баатрын үр хүүхэд, ач зээ нараас өөр дээдсийнхээ үйлсийг мөнхжүүлэхээр цогц арга хэмжээ авч хүчин зүтгэж байгаа хүмүүс бий бил үү. Баатрын маань үр хүүхэд, ач зээ нар цаашид аавынхаа дурсгалыг оюунлаг талаас нь мөнхжүүлэхээр санаа шийдэж эцгийнхээ байгуулсан гавьяа, хэлсэн үг, дурдатгал дурсамжийг эмхэтгэж гаргахад дэм тус үзүүлэхийг Улсын Хил хамгаалах байгууллагын командлалаас хүсчээ. Командлал эл саналыг тааламжтай хүлээн авч, хэрэгжүүлэхэд туслахыг Хил судлалын Төвдөө үүрэг болгосон ажээ. Тус төв, Жамбаа гуайн хүүхдүүд санаа бодлоо харилцан солилцсоны эцэст Хилийн цэргийг сурталчилахаар баатрын хамт удаа дараа томилогдон явсан хийгээд Халхын голын отрядын түүхийг бичсэний хувьд Хил хамгаалах байгууллагын 80 жилийн ойд зориулан энэхүү эмхэтгэлийг хянан үзэж эх сурвалжуудаар баяжуулахыг надад санал болгосон юм.

Тэгэхдээ хилийн цэргээс төрсөн баатруудын тухай манай зохиолч, сэтгүүлчид сайхан бүтээлүүд туурвидаг ч зарим нь бодит байдлыг хэтрүүлэх, дэгэсдүүлэх, зарим нь цэргийн нууцыг задруулж, үйл явдлыг бүр завхруулах явдал үзэгддэгээс түүнд анхаарлаа хандуулан засаж залруулахыг сануулсан билээ.

Мэргэшсэн сэтгүүлч, нийтлэгч, зохиолч нараас Жамбаа баатрын ажил амьдрал, баатарлаг үйлсийг уншигч,

үзэгчдийн ой тоонд ортол, ухаан санаанд буутал дүрслэж туурвисан утга төгөлдөр уран бүтээлүүдэд гар хүрнэ гэдэг надад ахадсан, нэгэн бодлын гэнэн гоомой үйлдэл гэлтэй.

Гэсэн ч эрхмүүдийн саналыг би бээр хүлээн авахаас өөр аргагүй байлаа. Учир нь Жамбаа баатар бид хоёр хэдүйгээр хожуу үеийн танил боловч албан томилолтоор Хилийн цэргийн анги, салбарууд, баатрын өөрийнх нь төрсөн нутаг Баянхонгор аймгийн Богд сум, аймгийн төвийн албан газруудаар олон хоног хамт явж дурдатгал дурсамжаа ярихыг чих тавин сонсож байсны хувьд, хоёрт гэвэл амралт сувилалын газар хамт амарч байхдаа ихэд дотносож чин сэтгэлийн үгийг нь лавлан сонирхож сүүл хэрдээ ижил дасал болсны хувьд арга буюу эмхэтгэлийг хянан тохиолдуулах саналыг хүлээн авсан болой.

Эх оронч Жамбаа баатрын гавьяат үйлсийн мөн чанар нь Халхын голын зарлаагүй дайны оршил, галын шугамын тэргүүн эгнээнд үүрэг гүйцэтгэж байсантай нэн уялдаатай болж өнгөрснийг нэхэн үзэхгүйгээр бие хүнийг нээнэ гэдэг хуудамгай хэрэг болох байсан болов уу. Завшаанаар би бээр сүүлийн 20 гаруй жил дорнод Монголын хил хязгаар түүний дотор Халхын голын дайны өмнөх үетэй холбогдсон архивын шаргал хуудсуудыг уйгагүй уншсан нь Жамбаа гуайн баатарлаг үйлсийг тодотгоход тус дөхөм болсон тал бий.

Энэхүү эмхэтгэлд орсон Жамбаа баатраас хурал, цуглаанууд дээр хэлсэн үг, дурсамжид ухаарч хэрэглэх, бахдан бишрэх, даган дуурайх, өвлүүлэн үлдээх, сургамж авах, судалж гүнзгийрүүлэх олон учир шалтгаан буй.

Нэгэн жишээг цухас дурьдахад: 1939 оны долдугаар сард Зөвлөлтийн Хилийн цэргийн отряд хамгаас урьд Халхын голд хүрэлцэн ирж Монгол хилчдэд хүч нэмэгдүүлж, мөр зэрэгцэн тулалдаж байсныг баатар маань дурдатгалдаа хөндсөн байх юм. Гэтэл тэр отрядыг хаанаас хэдүйд хэрхэн байгуулж, чухам ямар нэртэй газруудад тулалдсаныг цаашид гүнзгийрүүлэн судлах нь чухал билээ.

Өнгөрсөн хугацаанд Жамбаа баатрын амьдрал тэмцлийг тал бүрээс нь цэгнэн бичсэн мэргэд цөөнгүй. Энэ нь Жамбаа хэмээгч хүн аль хэдийн төр, түмний хүртээл болсны илрэл мөн. Манай сэтгүүлчид, зохиолчид Жамбаа баатрыг магтан дуулахдаа түүний дайсантай нүүр учиран тулгарч тулалдаж байсныг өөрсдийн байр сууриас дүгнэж, харилцан адилгүй бичсэн нь олон байх юм.

Энд ганц баримт дурьдахад сэтгүүлч Х.Оюунсүрэн 2002 оны “Өдрийн сонины” 148 (1021) дугаарт Жамбаа гуай урьд өдөр нь агаарын дайралтын хамгаалалт хийж байх зуур бууных нь жадыг дайсан зад буудчихсан, дараахан нь дайсны талаас тавьсан сум бууны ам руу ороод буугий нь гацаачихсан тул Цэвэгжав комиссартай ноцолдож байсан Япон даргын дэргэдэх арав гаруй цэрэгтэй Жамбаа гуай ноцолдож, тонгорч унагаад устгаад байсан хэмээн итгэхэд бэрх зүйл бичсэн байв.

Гэтэл 2003 онд Оргил рашаан сувилалд Жамбаа баатар надтай хамт амарч байх үеэр би бээр түүнээс та Цэвэгжав гуайн амийг хэрхэн хамгаалсан юм бэ гэсэнд:

- Тэр тун ярвигтай тохиолдол болсон юм. Цэвэгжав комиссар хил эргэхээр намайг дагуулан морин уналгатай

явж байтал Өмхий булагийн орчим манай хилийн дотор хүний толгой шовосхийхийг харсан. Бид хоёр тэднийг бүсэлсэн, ойртож ирмэгц эхлээд комиссар, дараа нь би “Зогс. Буугаа хая!” гээд нэгэн зэрэг команд өгсөн. Дайсан балмагдсандаа зэвсгээ газар шидээд гараа өргөсөн.

Тэгэхээр нь бид хоёр тулж очоод дайсны ахлагч нь бололтой япон офицерыг Цэвэгжав комиссар нэгжиж эхэлмэгц нөгөө этгээд өөдөөс нь дайрч ноцолдоод дээр дороо орсон. Би дайсны толгойг бууныхаа бөгсөөр цохисонд комиссарын толгой ташираар тохиолдсоноос Цэвэгжав түр ухаан алдсан. Гэвч комиссар маань дорхноо сэхэж би их баярласан гэж билээ. Чингэхэд нь би бээр:

Дайсны цэргүүд та нарыг хараад зогсоод байсан юм уу? гэсэнд Жамбаа гуай: Би чинь хоёр даргыг ноцолдмогц дайсны цэргүүдийг буудаж устгасан. Тэгж өрсөхгүй бол тэр олон хүн чинь бид хоёрыг дор нь эд бад хийнэ шүү дээ. Дайтаж байгаа хоёр талын цэрэг гэдэг өрсөж амиа хамгаалахаас өөр арга байхгүй гэх зэргээр хуучилсансан. Энэ бодитой баримтыг улсын баатар П.Чогдонгийн дурсамж, бусад эх сурвалжид нотолсныг энэхүү эмхэтгэлд оруулсан болно. Сэтгүүлчид хэдийгээр иймэрхүү зөрүүтэй зүйлийг бичсэн ч зохиогчийн эрхэнд халдахгүйг эрхэмлэж энэ мэт зарим баримтыг хэвээр үлдээсэн тул уншигч Та өөрийн байр сууриас тунгаан үзнэ биз ээ.

Монголын сэтгүүлчдийг бэлтгэдэг алба, амины сургуулиудын хөтөлбөрт цэрэг, эх оронч сэдэвтэй бичлэгийг хэрхэн бичих асуудлыг орхигдуулж ирснээс манай зарим сэтгүүлч баатарлаг хүмүүсийн амьдрал үйлсийг бичихдээ

анги, салбарыг хольж хутгах, тэдний нууцалсан дугаар, байрлал, бүтэц, бүрэлдэхүүн, зэвсэглэл, хангалт үйлчилгээ, зарим албан тушаалтны нэрлэхийг хориглосон нууцын тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх жагсаалтуудыг илчлэн задруулж, хууль зөрчсөнийг засах хэмээн оролдлоо.

Сэтгүүлч Т.Нямгэрэл “Эх орны манаа” сонины 2011 оны №27(2657)-д хилийн анги, салбарын байрлал, нууц дугаарыг задруулсан дутагдлыг өөрчлөн засварлаж, Жамбаа баатрыг улс төрийн хэлмэгдэлд өртсөнөөр бичсэн нь үндэслэл муутай байснаас тэр хэсгийг шууд хасахаас өөр аргагүй байлаа. Мөн тэр дугаарт “Дэлхийд гуравхныг бүтээсэн Жанрайсиг бурхны хоёр нь Монголд байдаг...” гээд гурав дахь нь хаана буйг дурдаагүйгээс уншигчдад эргэлзээ төрүүлэхээр бичсэн тул тухайн өгүүлбэрийг хасаад зохиогчийн санааг хүндэтгэж Их бурхны цогцолборыг Тогтохтөр ван хил хязгаар, газар нутгаа хамгаалах зорилгоор хэдий хэмжээтэй, хэрхэн бүтээснийг тодотгов.

Нэртэй том эрдэмтдийн бүтээлд ч ташаарал байсанд гар хүрлээ. Тухайлбал: Монгол Улсын Соёл, Шинжлэх ухааны Яам, Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэн, Оросын Шинжлэх Ухааны Академийн Сибирийн салбарын Монгол, Төвд, буддийн судлалын хүрээлэнгээс Халхын голын ялалтын 70 жилийн ойд зориулж, “Халхын гол: 1939” бүтээлд Жамбаа баатрыг 1938 онд Улаанбаатарт даргын сургууль төгсгөж, Хилийн цэргийн 7 дугаар заставт салбарын даргаар томилогджээ. (Уг бүтээлийн 197 дахь тал) гэж бичсэн нь ташаарал болжээ.